

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР**

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр:

**ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ӨНДӨГ ХУСАЖ
ЦУГЛУУЛАХ МЕХАНИК АРГААР ТЭМЦЭХ**

Тендер шалгаруулалтын дугаар:

ОйГ/2024020157

Улаанбаатар хот
2024 он

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

| | |
|-------------------------------|--|
| Огноо: | 2024.03.29 |
| Тендер шалгаруулалтын төрөл: | Ажил |
| Тендер шалгаруулалтын нэр: | ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ӨНДӨГ ХУСАЖ ЦУГЛУУЛАХ МЕХАНИК АРГААР ТЭМЦЭХ |
| Тендер шалгаруулалтын дугаар: | ОйГ/2024020157 |
| Нийт төсөвт өртөг: | 135,000,000.00 (нэг зуун гучин таван сая) төгрөг |
| Тендер шалгаруулалтын арга: | Харьцуулалт |

1. **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ОЙН ГАЗАР** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: *Үүнд:*

Багц № 1: Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн санд;

Багц № 2: Хэнтий аймгийн Дадал сумын ойн санд;

Багц № 3: Хэнтий аймгийн Норовлин сумын ойн санд;

Багц № 4: Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд;

3. Унийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **1 дээш**

4. Унийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам**

5. Унийн санал дуудах ажиллагааг:

Огноо: **2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр**

Цаг: **10 цаг 30 минутаас 13 цаг 00 минутын хугацаанд зохион байгуулна.**

6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:

Огноо: **2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр**

Цаг: **10 цаг 00 минут**

Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр нээнэ.

Огноо: **2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр**

Цаг: **10 цаг 30 минут нээнэ.**

7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”**

8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“ЭРХГҮЙ”**

9. Тендер хүчинтэй байх хугацаа:

Тендер нээнээс хойш ажлын 30 хоног дуустал хугацаанд хүчинтэй байна.

10. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“ТИЙМ”**

ТӨСӨӨВТ ӨРТГИЙН 0.5 ХУВИАР ТОГТООНО.

11. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 301 ТООТ.**

Утасны дугаар: **7711-1180**

Цахим шуудангийн хаяг: info@forest.gov.mn

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА

БОЮУНСААА

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ Өндөг хусаж цуглуулах механик аргаар
тэмцэх харьцуулалтын аргаар ажил гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах тендерийн баримт бичиг

Тендер шалгаруулалтын нэр:

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ Өндөг хусаж
цуглуулах механик аргаар тэмцэх

Тендер шалгаруулалтын дугаар:

ОйГ/2024020157

Улаанбаатар хот
2024 он

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

| | |
|--|----|
| I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА | |
| II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ..... | |
| III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА..... | |
| IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ | 32 |
| V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ | 36 |

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | | |
|---|-------------------|--|
| 1. Тендерийн хүрээ | цар | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил (цаашид “ажил” гэх) гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | | 2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| 3. Худалдан авах ажиллагааны тогтоомж | авах хууль | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө. |
| | | 3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |
| 4. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага | | 3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 ¹ , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй. |
| | | 4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна. |
| | | 4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр хуульд заасан ерөнхий шаардлага хангасан байна. |
| | | 4.3. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно. |
| | | 4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй. |
| | | 4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. |
| 5. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага | | 5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгүүлэх мэдээллийг гэрээнд заасан байна. |
| | | 5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй. |

6. Худалдан авах ажиллагааны цахим систем

7. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тодруулах

9. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

6.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

Б.АГУУЛГА

7.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;

V Бүлэг. Гэрээний нөхцөл

7.2. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

8.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

8.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

8.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

8.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

8.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 9-д заасныг мөрдөнө.

9.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

9.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн

| | | |
|--|--|--|
| | | хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана. |
| 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт | | 10.1. Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. |
| 11. Тендер шалгаруулалтын хэл | | 10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно. |
| | | 10.3. Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно. |
| | | В.Тендер бэлтгэх |
| 12. Тендерийн бүрдэл | | 11.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ. |
| | | 11.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно. |
| | | 11.3. Хэрэв ТШЗ-ны 11.2 заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална. |
| | | 11.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна. |
| иж | | 12.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ: |
| | | 12.1.1. ТШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягууд; |
| | | 12.1.2. Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/; |
| | | 12.1.3. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал; |
| | | 12.1.4. ТШЗ-ны 15-д зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг; |
| | | 12.1.5. ТШЗ-ны 16, 17, 18-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг; |
| | | 12.1.6. ТШЗ-ны 19-д заасны дагуу техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу ажил гүйцэтгэхийг нотлох баримт бичиг; |

| | | |
|-----|--|--|
| | | 12.1.7. ТШЗ-ны 22.4-д заасан тохиолдолд холбогдох тайлбар; |
| 13. | Тендерийн жишиг маягт | 12.2. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. |
| 14. | Хувилбарт санал | 13.1. Оролцогч IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ. |
| 15. | Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг | 14.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно. |
| 16. | Чадавхын болон туршлагын шаардлага | 15.1. IV бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэсэн хуулийн 7.2-т заасан мэдэгдэл ирүүлнэ. 15.2. ТШЗ-ны 4.1, 15.1-д заасан маягтыг магадлахтай холбоотой ирүүлэх баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заана. 15.3. Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх ба нотлох баримт бичиг ирүүлнэ. |
| 17. | Санхүүгийн чадавхын шаардлага | 16.1. Захиалагч ТШЗ-ны 17, 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 16.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 16.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 17, 18-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна. 16.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 17, 18-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. |
| 18. | Техникийн болон туршлагын шаардлага | 17.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 17.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 17.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 17.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойши хөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгуулагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй. 18.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын |

- шаардлагыг хангасан байна.
- 18.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.4. ТШЗ-ны 18.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
19. Ажлыг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэхийг нотлох баримт
20. Тендерийн үнэ
21. Тендерийн валют
22. Тендерийн үнэ
- 19.1. Оролцогч үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон эцсийн үнээр захиалагчийн баталсан техникийн тодорхойлолт, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэх тухай мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ.
- 20.1. Үнийн санал ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.
- 20.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 20.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
- 22.1. Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.
- 22.2. Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 22.3. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 22.4. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер

| | | |
|--|-----------------|---|
| | | шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ. |
| 23. Тендер байх хугацаа | хүчинтэй | <p>23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээнээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.</p> <p>23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>23.3. Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэх ба ТШЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.</p> |
| 24. Тендерийн баталгаа | | <p>24.1. Хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>24.2. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.</p> |
| 25. Тендер баталгаажуулах, илгээн | | <p>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</p> <p>25.1. Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2. Тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ-ны 24-т зааснаар илгээнэ.</p> <p>25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй.</p> <p>25.6. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p> |
| 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа | | <p>26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.</p> |

Д.УНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА

| | | |
|---|--------------|--|
| 27. Үнийн дуудах хугацаа | санал | 27.1. Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дараа эхэнэ. |
| 28. Тендер нээх | | 27.2. Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана. |
| | | 27.3. ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана. |
| 29. Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх | | 28.1. ТШЗ-ны 27.3-т заасан хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ. |
| 30. Тендерийн талаар тодруулга авах | | Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ |
| 31. Мэдэгдэл хүргүүлэх | | 29.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 12-т заасан тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ. |
| 32. Гүйцэтгэлийн баталгаа | | 29.2. Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмблэгдсэн тендерийг хянан үзнэ. |
| 33. Урьдчилгаа төлбөр | | 30.1. Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална. |
| 34. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | | Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ |
| | | 31.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| | | 32.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. |
| | | 32.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана. |
| | | 33.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | | 33.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 33.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ. |
| | | 34.1. Захиалагч ТШЗ-ны 7.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. |

34.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

34.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 34.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ.

34.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

Ж.БУСАД

35. Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах

35.1. Захиалагч ТШЗ-ны 29.2-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг ТШЗ 31.1-д заасан шийдвэрт заана.

35.2. Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.

36. Тендер шалгаруулалтад гомдол гаргах

36.1. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу хянан шийдвэрлэнэ.

П БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|-------------------------|--|
| ТШЗ-ны холбогдох заалт | А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
| ТШЗ 1.1 | Захиалагчийн нэр: ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ОЙН ГАЗАР |
| ТШЗ 1.1 | <p>Зарлалын дугаар ОйГ/2024020157</p> <p>Тендер шалгаруулалтын нэр: ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ӨНДӨГ ХУСАЖ ЦУГЛУУЛАН УСТГАХ МЕХАНИК АРГААР ТЭМЦЭХ</p> <p>Тендер шалгаруулалтын багцуудаас бүрдэнэ: Үүнд:</p> <p style="padding-left: 2em;">Багц № 1: Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн санд;</p> <p style="padding-left: 2em;">Багц № 2: Хэнтий аймгийн Дадал сумын ойн санд;</p> <p style="padding-left: 2em;">Багц № 3: Хэнтий аймгийн Норовлин сумын ойн санд;</p> <p style="padding-left: 2em;">Багц № 4: Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд;</p> |
| ТШЗ 2.1 | <p>Санхүүжилтийн эх үүсвэр: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ</p> <p>Нийт төсөвт өртөг: 135,000,000.00 (нэг зуун гучин таван сая) төгрөг.</p> <p style="padding-left: 2em;">Багц № 1: 36,000,000.00 (гучин зургаан сая) төгрөг.</p> <p style="padding-left: 2em;">Багц № 2: 36,000,000.00 (гучин зургаан сая) төгрөг.</p> <p style="padding-left: 2em;">Багц № 3: 36,000,000.00 (гучин зургаан сая) төгрөг.</p> <p style="padding-left: 2em;">Багц № 4: 27,000,000.00 (хорин долоон сая) төгрөг.</p> |
| Б.АГУУЛГА | |
| ТШЗ 8.1 | <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 301 тоот</p> <p>Хариуцсан ажилтан: ОЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАТ</p> <p>Хаяг: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 301 ТООТ</p> <p>Утасны дугаар: 7711-1180</p> <p>Цахим шуудан: info@forest.gov.mn</p> |
| ТШЗ 10.1 | Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: “ҮГҮЙ” |
| В.ТЕНДЕР БЭЛТГЭХ | |
| ТШЗ 11.2 | Тендер шалгаруулалтын хэл: “МОНГОЛ ХЭЛ” |

| | |
|----------|---|
| | |
| ТШЗ 14.1 | Хувилбарт санал ирүүлэхийг: “ЗӨВШӨӨРӨХГҮЙ” |
| ТШЗ 15.2 | <p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: “ШААРДАНА”</p> <ol style="list-style-type: none"> 1. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГҮҮЛСЭН ГАЗАР, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХЯЯГИЙГ ТОДОРХОЙЛСОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХЭЭС ХИЙСЭН ХУУЛБАР, ЭСВЭЛ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ БУСАД БАРИМТ БИЧИГ; 2. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭТГЭЭДИЙН ИТГЭМЖЛЭЛ; 3. ШҮҮХИЙН ТУСГАЙ АРХИВЫН ЛАВЛАГАА, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ТОДОРХОЙЛОЛТ, ТАТВАРЫН ӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТ, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАТВАРЫН ӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ИРҮҮЛНЭ. <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагaa авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагaa цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. - Жич: Дээр 2 лавлагaa авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу, 4. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨЛТИЙГ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс шалгана. 5. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 4.1.5-Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БУХИЙ “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГУЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО. (“ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ WWW.SAINSCORE.MN, WWW.BURENSCORE.MN ХАЯГААР ХАНДАН АВНА. |

| | |
|----------|---|
| | <p>6. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ: ТҮРГЭН ХӨРВӨХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 50 ХУВИАС БАГАГҮЙ БАЙНА.</p> <p>7. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ДАРААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН АЛЬ НЭГЭЭР ЭСВЭЛ НИЙЛБЭРЭЭР ТУС ТУС ТОДОРХОЙЛНО. ҮҮНД:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дансны үлдэгдэл* /Харилцагч банкны тодорхойлолт, тендер нээхээс 7 хоногийн өмнө харилцагч банкнаас авсан байх/ - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. Тухайн зээл нь судлагдсан байх шаардлагатай. Тухайн тендерийн ажилтай холбоотой ямар нэгэн нөхцөл шаардлага тавихгүйгээр олгох зээлийг үнэлгээнд авч үзэх бөгөөд бусад тохиолдолд тус шаардлагыг хангаагүй гэж үзнэ. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд. /Хувь хүн эзэмшиж буй үнэт цаас, хадгаламж хамаарахгүй/ <p>8. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН ГЭРЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ: “ШААРДАХГҮЙ”</p> |
| ТШЗ 17.1 | <p>Санхүүгийн чадавхын шаардлага“ШААРДАНА”</p> <p>2021, 2022, 2023 ОНУУДЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ НЬ БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 100 ХУВИАС БАГАГҮЙ БАЙНА.</p> |
| ТШЗ 17.2 | <p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>2021, 2022, 2023 ОНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛНЭ.</p> |
| ТШЗ 18.1 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “ШААРДАНА”</p> <ol style="list-style-type: none"> 1. 2021, 2022, 2023 ОНУУДАД ДОР ХАЯЖ ХОЁР БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨСӨВТ ӨРТГИЙН 100 ХУВИАС БАГАГҮЙ УНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА. УГ АЖЛЫН ГЭРЭЭ, АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ЗАХИАЛАГЧИЙН ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТЫГ ХАВСАРГАНА. 2. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН САНАЛ БОЛГОСОН НИЙТ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН, АЖИЛЧДЫН 60-ААС ДООШГҮЙ ХУВЬ НЬ ӨӨРИЙН ҮНДСЭН АЖИЛТАН, АЖИЛЧИД БАЙНА. САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТӨЛСӨН |

БОЛОХЫГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАЖ УЗНЭ. ХЭРЭВ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БОЛ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕР ГЭЖ УЗНЭ.

- 3. ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙГ УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛСАН ТАНИЛЦУУЛГА ИРҮҮЛЭХ,**

| Гүйцэтгэх үүрэг | Мэргэжил | Тоо | Мэргэжлээрээ ажилласан жил | Үндсэн /Гэрээт эсэх/ |
|-----------------|-------------|-----|----------------------------|----------------------|
| Ерөнхий инженер | Ойн инженер | 1 | 10 | Үндсэн |
| Ойн инженер | Ойн инженер | 1 | 3 | Үндсэн |
| Биологич | Биологич | 1 | 3 | Гэрээт |
| Жолооч | Жолооч | 1 | 9 | Гэрээт |
| Улирлын ажилтан | | 10 | 1 | Гэрээт |

- **ҮНДСЭН АЖИЛТАНЫ МЭДЭЭЛЛИЙГ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"-ЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАНА.** “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>
- **ГАДААДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨН БОЛ ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ОРЧУУЛАН ИРҮҮЛНЭ.**
- **ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧДАД ОЛГОСОН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ, ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ГЭРЧИЛГЭЭГ ТУС ТУС НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭН ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛД ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.**
- **ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БОЛОХЫГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"- ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. СҮҮЛИЙН 6 САР ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БАЙХ ШААРДЛАГАТАЙ. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНУУДЫН БИЧИГ БАРИМТЫГ ДУТУУ ИРҮҮЛЭХ,**

| | |
|--|---|
| | <p>НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ДЭЭР ДУРДСАН ХУГАЦААНД ТӨЛӨГДӨӨГҮЙ ТОХИОЛДОЛД УГ ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.</p> <ul style="list-style-type: none"> - ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙСАН ТУРШЛАГАТАЙ ОЙН АЖ АХУЙН ИНЖЕНЕР, ОЙ ЗҮЙЧ, БИОЛОГИЧ, ШАВЖ СУДЛААЧ БАЙХ. <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “ШААРДАНА”</p> <ul style="list-style-type: none"> - ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛУУДЫГ ЗӨӨВӨРЛӨХ БАГА, ДУНД ОВРЫН АВТОМАШИНУУД; - ӨНДӨГ ХУСАЖ ЦУГЛУУЛАХ ТӨРӨЛ БУРИЙН МАЛТУУРУУД; - ӨНДӨГ ЦУГЛУУЛАХ ТӨРӨЛ БУРИЙН ХЭМЖЭЭТЭЙ ШУУДАЙ, - ЦУГЛУУЛСАН ӨНДӨГНИЙ ЖИНГ ХЭМЖИХ ГАР БОЛОН ЭЛЕКТРОН ЖИН, - ХЭЭРИЙН АЖИЛД АЖИЛЧДЫН БАЙРЛАХ ГЭР, МАЙХАНТАЙ БАЙХ, ТЭМЦЛИЙН АЖЛЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ СУДАЛГААНЫ АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ ШАВЖ ЦУГЛУУЛАХ ДЭЛГЭЦҮҮДТЭЙ БАЙХ, - БАЙРШИЛ ТОГТООГЧ GPS, - БИЧИЛ ЦАГ УУР ХЭМЖИГЧ, - ОЙН БҮРТГЭЛ ТООЛЛОГЫН ХЭМЖИЛТИЙН БАГАЖУУД - ШАВЖ ҮХҮҮЛЭХ, ХАДГАЛАХ САВ, - ШАВЖ БАРИХ ХОВОЙ, (САЧОК) - СОРОГЧ БАГАЖ, - ШТАНГЕНЦИРКУЛЬ, - ШАВЖ БАРИХ УРХИ (ЛОНХОН, ТАВГАН, ГЭРЛЭН), - ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМУУДЫН ЖАГСААЛТЫГ V БУЛГИЙН МАЯГТ-8 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ. ТҮРЭЭСЭЭР ХЭРЭГЛЭХ БОЛ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ НОТАРИАТААР БАТЛУУЛЖ, ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭГ ХАВСАРГАНА. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖИЙН ХУВЬД ФОТО ЗУРГИЙГ ИРҮҮЛНЭ. <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага:“ШААРДАНА”</p> |
|--|---|

- СҮҮЛИЙН З ЖИЛ БУЮУ 2021, 2022, 2023 ОНУУДАД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ЖАГСААЛТЫГ ИРҮҮЛНЭ. ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГУУДЫГ ӨМНӨХ ЗАХИАЛАГЧТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ӨМНӨХ ЗАХИАЛАГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ҮНДЭСЛЭН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАН ҮЗНЭ. /ижил төстэй ажил гэдэгт ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил гүйцэтгэж байсан туршлагыг голлон авч үзнэ./ СҮҮЛИЙН З ЖИЛД НИЙЛҮҮЛСЭН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХАНГАЛТГҮЙ БАЙСАН НЬ ӨМНӨХ ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОДОРХОЙЛОЛТООР БОЛОН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТААР НОТЛОГДСОН ТОХИОЛДОЛД ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.
- БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН УНИЙН ДУНГИЙН 100 ХУВИАС БАГАГҮЙ УНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫГ ТШЗ 19.1-Т ЗААСАН ХУГАЦААНД ДООД ТАЛ НЬ НЭГ УДАА ГҮЙЦЭТГЭСЭН БАЙХ.

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:
“ШААРДАНА”

| № | Гэрээний нэр | Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Дууссан эсвэл дуусах хугацаа |
|---|--------------|---|--------------|------------------------------|
| | | | | |

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “ШААРДАНА”

- ЗАХИАЛАГЧ ХАРИЛЦАГЧ БАНК, НИЙГМИЙН ДААТГАЛ, ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГУУДААС ТОДОРХОЙЛОЛТ ХҮСЭХЭД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛГҮЙ ТУХАЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН АЛБАН МЭДЭГДЭЛ,
- ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,
- АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ЧАНАРЫН ЗӨРЧИЛ, ГОЛОГДОЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ТҮҮНИЙГ ЗАСАХ, ЗАЛРУУЛАХ ТУХАЙ ШААРДЛАГА ӨГӨХӨД ҮЛ МАРГАЛДАХ ЖУРМААР БИЕЛҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,
- ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ДАГУУ ТООЦСОН ТӨСӨВ ИРҮҮЛНЭ. УГ ТӨСӨВТ ХОЛБОГДОХ ТАТВАР

| | |
|----------|---|
| | <p>ХУРААМЖ, ДААТГАЛЫГ БҮРЭН ХАМРУУЛСАН БАЙНА.</p> <ul style="list-style-type: none"> - ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ, ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ БАТАЛГААЖУУЛЖ ИРҮҮЛЭХ, - САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ БАЙГУУЛСАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, НОТАРИАТААР БАТАЛГААЖУУЛАН ИРҮҮЛЭХ, - ТЕНДЕРТ ШАЛГАРСАН ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ЗАХИАЛАГЧААС ТОГТООСОН ҮЕ ШАТНЫ ХУВААРТЬ ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ ЧАНАРЫН ӨНДӨР ТҮВШИНД ТУХАЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭН ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БАТАЛГААГ БИЧГЭЭР ГАРГАЖ ИРҮҮЛНЭ. - СҮҮЛИЙН з жилийн аль нэг жилд хийж ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХИЙСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ. ГЭРЭЭ БОЛОН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН ГЭРЭЭ ДУГНЭСЭН АКТЫН ХУУЛБАРЫГ ХАВСАРГАНА. ДУУСААГҮЙ ГЭРЭЭНИЙ ХУВЬД ТАЙЛБАР ХИЙСЭН БАЙНА. - ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ОЛОН БАГЦАД ТЕНДЕР ИРҮҮЛЭХ БОЛОН ӨӨР ИЖИЛ ТӨРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БОЛ ЗӨВХӨН ТУХАЙН БАГЦАД АЖИЛЛУУЛАХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫГ САНАЛ БОЛГОСОН ТЕНДЕР ИРҮҮЛНЭ. (ХЭРЭВ ЗАХИАЛАГЧИЙН ЗАРЛАСАН БУСАД ТЕНДЕРҮҮДЭД САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАН ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.) |
| тшз 18.2 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>“ШААРДАНА”</p> <ul style="list-style-type: none"> - ШААРДСАН ХУНИЙ НӨӨЦИЙГ МЭДЭЭЛЛИЙГ V БҮЛГИЙН МАЯГТ-7 ДАГУУ ИРҮҮЛЭХ; - ОРОЛЦОГЧИЙН ТУРШЛАГЫГ ХАРУУЛАХ ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭНИЙ ТАЛААР V БҮЛГИЙН МАЯГТ-3 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ; - АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД АШИГЛАХААР ЗААСАН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, (ӨӨРИЙН ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШЛИЙН, ТҮРЭЭСЛЭХ ГЭХ МЭТ) ТАЛААР V БҮЛГИЙН МАЯГТ-8 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ; - ТЕХНИКИЙН ЧАДАВХ БОЛОН ТУРШЛАГЫН ТАЛААР |

| | |
|------------------------|--|
| | ЗААСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙГ НОТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БУСАД БАРИМТЫГ ХАВСАРГАН ИРҮҮЛЭХ. |
| ТШЗ 18.3 | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “ШААРДАНА”</p> <p>“ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫН 4.1.2 ДАХЬ ЗААЛТАД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА. ҮҮНД:</p> <ul style="list-style-type: none"> - ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧНИЙ СУДАЛГАА ХИЙХ, ТЭДГЭЭРТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХТЭЙ БАЙХ <p>ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА НЬ ДООР ДУРДСАН ШАЛГУУРЫГ ХАНГАСАН БАЙНА. ҮҮНД:</p> <p>(ажил гүйцэтгэхээр заасан хугацаанаас хойш 3 сараас доошгүй хугацаанд хүчинтэй байна)</p> |
| ТШЗ 20.2 | Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ТОХИРУУЛАХГҮЙ ТОГТМОЛ БАЙНА” |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дун: 675,000.00 (зургаан зуун далан таван мянган) төгрөг</p> <p><i>Багц №1: 180,000.00</i> (нэг зуун наян мянган) төгрөг, <i>Багц №2: 180,000.00</i> (нэг зуун наян мянган) төгрөг, <i>Багц №3: 180,000.00</i> (нэг зуун наян мянган) төгрөг, <i>Багц №3: 180,000.00</i> (нэг зуун наян мянган) төгрөг,</p> <p>Тендерийн баталгааг материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерийн баталгаа гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна. Захиалагч тендерийн баталгааг хуулийн 28.1.1-д зааснаар “хамгийн сайн тендер ирүүлсэн” оролцогчид гэрээ байгуулсны дараа цахим системээр хүчингүй болгоно. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны едрийн А/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.3.3 дахь хэсэгт заасны дагуу цахим системээр дамжуулан тендерийн баталгааг ирүүлнэ.</p> <p>Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа: Тендер нээсэн өдрөөс хойш ажлын 30 хоног дуустал хүчинтэй байна</p> |
| Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ | |
| ТШЗ 25.5 | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИУДААР ИЛ БОЛГОХЫГ ХОРИГЛОСОН МЭДЭЭЛЛИЙГ ТУСАД НЬ ФАЙЛ ҮҮСГЭН ИРҮҮЛНЭ. ТУС ФАЙЛЫН ЭХЭНД ТЭДГЭЭР МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ ҮНДЭСЛЭЛИЙГ БИЧГЭЭР ТАЙЛБАРЛАЖ, ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД</p> |

| | |
|----------|--|
| | БАТАЛГААЖУУЛАН V БҮЛГИЙН МАЯГТ 5-ЫН ДАГУУ ИРҮҮЛНЭ. |
| ТШЗ 26.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь</p> <p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Үнийн санал дуудах хугацаа:</p> <p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минутаас 12 цаг 00 минут</p> <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр нээнэ.</p> <p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр</p> <p>Цаг: 12 цаг 00 минут нээнэ.</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 3 ДАВХАР, 301 ТООТ.</p> |

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭЖКҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ Өндөг хусаж цуглуулах МЕХАНИК АРГААР 7500 ГА ТАЛБАЙД ТЭМЦЭХ АЖИЛ

ТЭМЦЛИЙН АЖИЛ
ХИЙХ ГАЗРУУД,
ГҮЙЦЭТГЭХ
АЖЛЫН АГУУЛГА
ҮЕ ШАТУУД

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажил 7500 га талбайд:

Багц № 1: Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн санд 2000 га талбайд;

Багц № 2: Хэнтий аймгийн Дадал сумын ойн санд 2000 га талбайд;

Багц № 3: Хэнтий аймгийн Норовлин сумын ойн санд 2000 га талбайд;

Багц № 4: Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд 1500 га талбайд ажлыг зохион байгуулна.

БЭЛТГЭЛ

- Багаж тоног төхөөрөмжүүдийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг хавсарган ирүүлэх шаардлагатай.
- Өндөг хусаж цуглуулахад шаардлагатай бусад тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн, тэмцлийн ажилд гаргахад бэлэн болгосон байх;
- Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/
- Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээсэн байх;
- Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг явуулах технологийн карт боловсруулах;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ашиглах 1:100000-ын байр зүйн болон 1:50000-ны масштабтай ойн тархалтын зураг дээр тэмцлийн ажил явуулах талбайг тэмдэглэх;
- Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг бүртгэх загвар бэлтгэсэн байх;
- Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ажиллах

**ӨНДӨГ ХУСАЖ
ЦҮГЛУУЛАХ
МЕХАНИК АРГААР
ТЭМЦЭХ**

ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгч, тухай бурд нь зааварчилгааны хуудас дээр гарын үсэг зуруулан баталгаажуулна;

- Тэмцлийн ажилд ажиллах улирлын болон түр ажилчдыг дадлагажуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;
- Тэмцлийн ажил явуулах бүс нутгийн ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тухай мэдээ, зураглалтай танилцах, тэмцлийн ажил явуулах газар нутгийг судлан холбогдох бэлтгэлийг хангана

Доор дурдсан аймгуудын ойн сан бүхий сумдад тэмцэх ажлыг зохион байгуулна. Үүнд:

| д/д | Тэмцлийн ажил явуулах сумын нэр | Тэмцэл явуулах талбай, га |
|-----------------|--|---------------------------|
| 1 | Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн санд | 2000 |
| 2 | Хэнтий аймгийн Дадал сумын ойн санд | 2000 |
| 3 | Хэнтий аймгийн Норовлин сумын ойн санд | 2000 |
| 4 | Дорнод аймгийн Баян-Уул сумын ойн санд механик тавих аргаар тэмцэх | 1500 |
| НИЙТ ДҮН | | 7500 |

| д/д | Техникийн шаардлага | Нийлүүлэгчийн санал |
|-----|---|---------------------|
| 1. | 400 нанометрээс багагүй хэмжээтэй дусал бүхий мананцар үүсгэн ажлын шингэнийг шүрших боломжтой шуршигч багажуудтай байх | |
| 2. | Өндөг хусаж цуглуулах хусуур, цуглуулах савтай байх | |
| 3. | Түүсэн өндөгний хэмжээг гаргах электрон эсвэл гар жинтэй байх | |
| 4. | Үүргийн шуршигч багажууд нэг удаагийн цэнэглэлтээр 0.5 га-аас багагүй талбайг хамран шуршилт хийх боломжтой байх | |
| 5. | Шуршигч тоног төхөөрөмжийн моторын хүчин чадал 5 м.х-ээс багагүй байх ба шүрших өндөр нь 8 метр болон түүнээс их байх | |
| 6. | Бүрэн ажиллагаатай бэлдмэл бодис сорох гаргах мотопомптой байх. | |
| 7. | Ажил гүйцэтгэх хугацаанд | |

| | | |
|----|---|--|
| | багажийн техникийн үзүүлэлтээс хамааран 20-25 хоногийн хугацаанд багтаан тэмцлийн ажил явуулах боломжтой хэмжээний үүргийн шүршигч багажуудтай байх | |
| 8. | Ажлыг гүйцэтгэх хугацаа: 2024.05.01 – 2024.10.01 | |

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцсон байна.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх бус нутагт хяналтын талбай байгуулан тэмцлийн өмнөх болон дараа харьцуулсан үр дүнг гаргасан байна.

Тэмцлийн ажлын өмнөх судалгаа болон тэмцлийн ажлын үр дүн тооцох тус тус хүснэгтийг зааврын дагуу газар дээр нь бөглөсөн байх;

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, өдөр бүрийн түүсэн өндөгний жинг гаргаж, тэмцлийн ажлын маршрут, хөдөлгөөнийг байршил тодорхойлогч багажаар бүртгэн явсан замыг ship өргөтгөлтэй файлаар хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэн товч тайлан гарган ажиллана.

Уг гүйцэтгэлийн өдөр тутмын товч тайлан мэдээг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж буй төслийн менежерийн анхны шаардлагаар саадгүй хувилан өгөх үүрэгтэй.

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger платформыг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger платформд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/

Earthranger платформын эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээсэн байна;

Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлын байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршрутын мэдээг хуулж авч хадгалах;

Ойн хөнөөлт шавж, өвчний нарийвчилсан судалгаа хийх, суурин цэг байгуулах, тархалт, голомтыг тогтоох судалгааны ажлын явцын болон гүйцэтгэлийн мэдээ, видео, фото зураг хэлбэрээр тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим сошиал сувгаар мөн захиалагч байгууллага Ойн газрын хэвлэл мэдээллийн хариуцсан мэргэжилтэнд өдөр тутмын мэдээг тогтмол өгсөн байна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг тухайн багцад ажиллах

инженер, техникийн ажилтныг ажилласан байна. /Тухайн багцын удирдах болон инженер, техникийн ажилтнууд ажиллуулаагүй тохиолдолд гэрээт ажлыг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна./

Ойн хөнөөлт шавжтай Өндөг хусаж цуглуулах механик аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6532:2015”, стандартыг мөрдөж ажиллана.

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, талбайн байршилыг хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэх, газрын нэрээр гаргах, өдөр бүр түүсэн өндгийг жинлэн фото зургаар баталгаажуулан орон нутгийн ажлын хэсгийн төлөөллийг байлцуулан хогийн цэгт нүх ухаж булж устгасан товч тайлан гарган ажиллана.

Тэмцлийн ажил явуулсан талбайг орон нутгийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, захиалагчаас томилогдсон төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч, актыг хавар, намар гэсэн хоёр үе шатаар үйлдэн актын эх хувийг тайланд хавсарган ирүүлнэ.

Тэмцлийн ажлын үр дүнг тооцохдоо “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартыг мөрдөж ажиллана. Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцон хүлээн авна.

Тэмцлийн ажлын техникийн үр дүн 90%-аас багагүй байхад тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авна..

Зөрчил, гологдол арилгах

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахад гарсан зөрчил дутагдлыг гүйцэтгэгч залруулах үүрэгтэй.

Тэмцлийн ажлын үр дүн заасан хувь хэмжээнд хүрээгүй тохиолдолд гүйцэтгэгч тэмцлийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж дахин комисст хүлээлгэн өгнө.

Энэхүү шаардлагыг биелүүлж ажиллахаа тендерт оролцогч захиалагчид албан бичгээр тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Тайлан боловсруулах

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайланг аймаг тус бүрээр хийж захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан доор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- а/ “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”;
 - б/ 1:50000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулсан талбайн зураг;
 - в/ 1: 100000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчиний тархалтын тойм зураг.
- а. “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”-д:
Ойн хөнөөлт шавж, өвчиний тархалтын судалгаа явуулан хөнөөлт шавжийн тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэн ургах чадвараа алдсан талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл ялгарлын талбай бүрээр гарган хүснэгтээр оруулна.

Түүнчлэн зонхилон хөнөөл учруулж буй шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог шинжүүд, хөгжлийн үе шатуудын талаарх мэдээлэл, тоо толгойн нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг багтаана.

Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойн ерөнхий байдлын зураг, тэмцлийн ажлын үр дүнд ой сэргэн ургасан байдлыг харьцуулсан зургийг тайланд хавсаргана.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын бэлтгэл, зохион байгуулалт, гүйцэтгэсэн хугацаа, бүрэлдэхүүн, ажил гүйцэтгэсэн технологийн мэдээлэл, тэмцлийн ажил явуулсан талбайн мэдээллийг тайланд багтаах ба тэмцлийн ажил явуулсан талбайн зураг, орон нутагт хүлээлгэн өгсөн актыг эх хувиар хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн тэмцлийн ажил эхлэхийн өмнө дээж талбай байгуулан хөнөөлт шавжийн нягтшилыг тодорхойлсон мэдээллийг дээж талбай тус бүрээр, үр дүнг тооцоо байгуулсан дээж талбай дээрх тооллогын мэдээллийг тооллого хийсэн өдөр тус бүрээр гарган тайланд оруулна.

б. “Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.

Тэмцлийн ажил явуулсан талбайг арга тус бүрээр ялган харуулах ба талбайн хэмжээг тусад нь хүснэгтэд хийн зурагт хавсарган ирүүлнэ.

Ойн хөнөөлт шавжтай тэмцлийн ажил явуулсан талбайн зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

в. “Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг”-т ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг зүйлийн бүрэлдэхүүн тус бүрээр гарган харуулна. Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

Тайлланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р

сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.

Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх

МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫН ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын тайлан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Захиргаа, удирдлагын хэлтэс, Ойн нөөцийн хэлтэст тус тус нэг хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт нээлттэйгээр хэлэлцүүлнэ.

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Ерөнхий инженер нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 5 жилийн туршлагатай байх, түүн дотроо гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 жилийн туршлагатай байх
Инженер техникийн ажилтан нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх
5.0 мян/га талбай тутамд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд 5-аас дээш жил ажилласан мэргэшсэн инженер 2-ээс доошгүй, 5.0 мян/га талбай тутамд улирлын болон түр ажилтан 20-оос доошгүй байна.
Тэмцлийн ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /тогооч, жолооч гэх мэт/ байх.

ЗУРАГ

*Ойн хөнөөлт шавжтай өндөг хусаж цуглуулах
механик аргаар тэмцэх талбайн байришил харуулсан зураг*

/Хавсралт 1/

Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

| д/д | Зураг төслийн нэр | Агуулга |
|-----|---|--|
| 1. | Тэмцлийн ажил явуулах талбайн зураг | Тэмцлийн ажил явуулахаар төлөвлөж буй аймаг, сум тус бүрээр гаргах ба ажил гүйцэтгэх арга технологи тус бүрээр газар нутгуудыг тэмдэглэх, ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх |
| 2. | Тэмцлийн ажилд ашиглах багажийн зураг | Багажийн маркийг бүрэн гүйцэд харуулсан байх |
| 3. | Тэмцлийн ажилд ашиглах автомашинуудын зураг | Ажилд ашиглах машинуудын зургийг тус бүрд нь харуулах |
| 4. | Тэмцлийн ажилд ашиглах мотопомпнуудын зураг | Мотопомпнуудын марк, ус шахах, сорох шланкыг бүрэн гүйцэд харуулсан байх |
| 5. | Тэмцлийн ажилд ашиглах үүргийн шүршигч багажийн зураг | Шүршигчийн марк, үзүүлэлтүүдийг гүйцэд харуулсан байх |

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

| Д/Д | Ажлын нэр, тодорхойлолт | Тоо, хэмжээ | Нийлүүлэх хуваарь |
|-----|--|-------------|----------------------|
| 1 | Бэлтгэл ажил | - | 2024-04-25-ны дотор |
| 2 | Механик аргаар тэмцэх ажил /хавар/ | 7500 га | 2024-05-20-ны дотор |
| 3 | Механик аргаар тэмцэх ажил /намар/ | 7500 га | 2024-10-01-ний дотор |
| 4 | Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх /хавар/ | 7500 га | 2024-05-20-ны дотор |
| 5 | Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх /намар/ | 7500 га | 2024-10-01-ний дотор |
| 6 | Зөрчил, гологдол арилгах /хавар/ | 7500 га | 2024-05-20-ны дотор |
| 7 | Зөрчил, гологдол арилгах /намар/ | 7500 га | 2024-10-01-ний дотор |
| 8 | Тайлан боловсруулалтын ажил | - | 2024-10-10-ны дотор |
| 9 | Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх | - | 2024-11-10-ны дотор |

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөж шаардлагатай бүх маягтыг тусгана.

Агуулга

| | |
|---|----|
| <u>Маягт 1: Тендер илгээх маягт</u> | 33 |
| <u>Маягт 2: Ижил төстэй ажил нийлүүлсэн гэрээний мэдээлэл</u> | 34 |
| <u>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл</u> | 34 |
| <u>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл</u> | 34 |
| <u>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт</u> | 35 |

Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээши хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна¹
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон ажил нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догондолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг мэдээлэл:

Маягт 2: Ижил төстэй ажил нийлүүлсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|--------------|---|--------------|----------------------------|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцгчийн нэр: [түншилэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

| | |
|----|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |

Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|--------------|---|--------------|-----------------------|---|----------------|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

| | Нууцалсан баримт бичиг, мэдээлэл | Нууцалсан хууль зүйн үндэслэл |
|----|-------------------------------------|-------------------------------|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

Маягт 6: Тендерийн баталгаа

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол өөрийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан эрх бүхий этгээдийг заана уу.]

[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

Маягт 7: Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|--------------|-------------|---------------------------------|-----------------------------|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Маягт 8: Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл

| Машин механизмын тооног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | Горийн эзэмшил эсхүл “турээс” аль нэгийг бичих] |
|---|-------------|------------|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамгад нь нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;

1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;

1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан

журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн
нийтлэг үүрэг

2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.

2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.

2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.

2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

Гүйцэтгэгчийн
нийтлэг үүрэг

3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардлагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.

3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгчхариуцна.

3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 10 (арав) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.

3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн,

Гүйцэтгэгчийн
төлөөлөгч

- дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл
- Ажлын талбайн харуул хамгаалалт
- Хог, хаягдал ба нөхөн сэргээлт
- Археологийн болон бусад олдвор
- Аюулгүй байдал
- 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
- 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
- 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалыудыг зохих ёсоор хадгалж, устгана.
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;

4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;

4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.

4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.

4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.

4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ

5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

5.2. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.

5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

| | |
|-------------------------------|---|
| Үрьдчилгаа төлбөр | <p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p> <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |
| Төлбөрийн нөхцөл | ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА |
| Үрьдчилгаа төлбөрийн баталгаа | <p>6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.</p> <p>6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:</p> <ul style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| Гүйцэтгэлийн баталгаа | <p>6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг</p> |

- чөлөөлнө.
- Чанарын баталгаа
- 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ**
- Бусдад учруулсан хохирлыг арилгах
- 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн хүлээх эрсдэл
- 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

| | | |
|-----------------------------|---------|---|
| Даатгал | | <p>7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.</p> <p>7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.</p> <p>7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.</p> <p>7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.</p> |
| Доголдлыг илрүүлэх, арилгах | | <p>НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ</p> <p>8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.</p> <p>8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.</p> <p>8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.</p> <p>8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.</p> <p>8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.</p> <p>8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.</p> <p>8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.</p> <p>8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.</p> <p>8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.</p> |
| Далд доголдол | | <p>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</p> |
| Зураг төслийн доголдол | төслийн | <p>9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр</p> |
| Захиалагч | гэрээг | |

| | |
|----------------------|---|
| цуцлах | <p>ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;</p> <p>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;</p> <p>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгалын гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</p> <p>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 10 (арав)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</p> <p>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагaa эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</p> <p>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.</p> |
| Гүйцэтгэгч цуцлах | <p>9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.</p> <p>9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</p> <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.</p> |
| Гэрээг цуцлах журам | <p>9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> <p>9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.</p> |

| | |
|-------------------------------|---|
| Гэрээг цуцалсны дараах төлбөр | <p>9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.</p> <p>9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:</p> <ul style="list-style-type: none"> 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр; 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тооног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал; 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр; 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал; 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол. |
| АРАВ. БУСАД ЗААЛТ | |
| Мэдэгдэл | <p>10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.</p> <p>10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн. <p>10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.</p> <p>10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.</p> <p>10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.</p> |
| Төлөөлөгч өөрчлөгдөх | |

- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал
- Оюуны өмчийн эрх зөрчих
- Алданги
- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын өрөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-д заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.

Маргаан шийдвэрлэх

10.25. Гэрээнэс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 4.1. Ажил эхлэх хугацаа: **2024.05.10**
- ГЕН 4.2. Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: **2024.05.01**
- ГЕН 4.9. Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: **2024.07.01**
Шаардлагатай мэдээллийг урьдчилан авна.
- ГЕН 5.2. Үнийн тохируулга: “**ХИЙХГҮЙ**”
- ГЕН 5.4. Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “**ҮГҮЙ**”
- ГЕН 5.5. Урьдчилгаа төлбөр олгох хугацаа:
- ГЕН 5.6. Төлбөр төлөх хугацаа: **АЖЛЫН 14 ХОНОГ**
- ГЕН 6.1. Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: “**ҮГҮЙ**”
- ГЕН 6.8. Чанарын баталгаа: “**ШААРДАНА**”
- Чанарын баталгааны хэмжээ: **ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 5 ХУВЬ**
- ГЕН 6.14. Баталгаат хугацаа: **365 ХОНОГ.**
- ГЕН 7.5. Даатгал: **ГҮЙЦЭТГЭГЧ ХАРИУЦНА.**
- ГЕН 10.21. Захиалагчийн төлөх алдангийн хувь: **0.1 хувь**
Алданги: **ХОНОГ ТУТАМД ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 0.1 ХУВЬ**
- ГЕН 10.22. Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: **0.1 хувь**
Алданги: **ХОНОГ ТУТАМД ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 0.1 ХУВЬ**

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл даасан үнийн дүng тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
- 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
- 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
- 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
- 3.7. Техникийн тодорхойлолт;
- 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: *[Зарлал нийтлэх огноог бичих]*

Тендер шалгаруулалтын төрөл: Ажил

Тендер шалгаруулалтын нэр: *[төсөл, арга хэмжээний батлагдсан нэрийг бичих]*

Тендер шалгаруулалтын дугаар: *[цахим системд заасан тендер шалгаруулалтын дугаарыг бичих]*

Нийт төсөвт өртөг: *[нийт төсөвт өртгийг бичих]*

Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

12. *[Захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]* нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

13. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: *[Хэрвээ багцтай бол “Тийм”, багцгүй бол “Үгүй”]*

Багц № 1: багцын нэр,

Багц № 2: багцын нэр...гэх мэт.

14. Унийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: *[Унийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоог бичих]*

15. Унийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: *[Журмыг бичнэ үү.]*

16. Унийн санал дуудах ажиллагааг *[огноо, цаг]-д эхлүүлж, [хоёроос доошигүй цаг байхаар заана]* хугацаанд зохион байгуулна.

17. Тендерийг *[тендер хүлээн авах огноо, цаг]-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг *[огноо]-ны өдрийн, [цаг]-т нээнэ.**

18. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: *[“Зөвшөөрнө” эсхүл “Зөвшөөрөхгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]*

19. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: *[“Эрхтэй” эсхүл “Эрхгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]*

20. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

21. Тендерийн баталгаа шаардах эсэх: *[“Тийм” эсхүл “Үгүй”]* Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

22. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

[Захиалагчийн хаяг, утас/цахим шуудангийн хаяг]